

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Хөдөө аж ахуй, хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ний 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ХУРААНГУЙ тайлан

Аудитын код: БУА-2026/07/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт
Утас: 70342580 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342495 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Аудитор: Б.Энхтөр
Утас: 70342495 Цахим хаяг: enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.08.13 № 313

танай _____ ны № _____ т

“Хөдөө аж ахуй, хөгжлийн”
ИРЭЭДҮЙ” ОНӨХХК-ИЙ ЗАХИРЛЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
М.ЛХАГВАНЯМ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөдөө аж ахуй, хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ий 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Хөдөө аж ахуй, хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ий 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Иргэдийн төлөөлөгчийн хурлын 2025 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 8-р хуралдааны 59 тогтоолоор 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 634.3 сая төгрөг, нийт зардлыг 606.3 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Өмнөх оны үлдэгдэл 317.2 сая төгрөг бол гүйцэтгэлээр 439.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 515.1 сая төгрөгийн зарцуулалттай ажилласан байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт

6326050476

хөрөнгийн дүн өмнөх оноос 362.04 сая төгрөгөөр, авлага 599.3 сая төгрөгөөр, бараа материал 168.8 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ нь шинээр 2 автомашин, 18 ширхэг Павильон, Санхүүгийн программ, тоног төхөөрөмжүүдийг өөрийн хөрөнгөөр худалдан авсан, түрээсийн гэрээгээр тараагдсан трактор, тоног төхөөрөмж, аймгийн нөөцийн газрын өвс тэжээл нэмэгдсэнээр өссөн шалтгаантай байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	4,278,340	4,970,768
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,852,913	4,495,739
	Нийт хөрөнгийн дүн	9,131,253	9,466,508
	Нийт өр төлбөрийн дүн	0	0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9,131,253	9,466,508
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9,131,253	9,466,508
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	5,556,331	1,209,062
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,564,104	873,807.31
	Үйл ажиллагааны үр дүн	3,992,227	335,254.49
	Үйл ажиллагааны бус үр дүн	0	0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	3,992,227	335,254.49
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,139,026	9,131,253
	Тайлант оны үр дүн	0	335,254.49
	Эцсийн үлдэгдэл	9,131,253	9,466,508
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	582,817	539,403
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	273,814.05	399,773.10
	Үйл ажиллагааны ЦМГ	309,002.93	139,629.62
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-4,500	-215,350
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0	0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	304,502.93	-75,720.38
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,695.90	317,198.82
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	317,198.82	241,478.45
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	606.33	615.12
	Урсгал зардал	606.33	615.12
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
	Улсын төсвөөс санхүүжих		
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

Гурав: Байгууллага, түүний үйл ажиллагаа

“Хөдөө аж ахуй, хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ний зорилго нь Улс, орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээс нийлүүлэгдсэн хөрөнгө оруулалтаар иргэн, аж ахуйн нэгжийн орлого, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, шинэ технологи, инновацыг нэвтрүүлэх, аймгийн мал сүргийн бүтцийг сайжруулж, ашиг шимийг нэмэгдүүлэх, цаг үеийн онцгой байдал, гамшгийн үед хэрэгцээтэй хүнс, малын тэжээл, өвс, шатахуун, орон гэр, хамгаалалтын хувцасны нөөцийг бэлтгэх, стандартын дагуу хадгалж, шаардлагатай үед хэрэгцээтэй газруудад түгээх, худалдан борлуулах, нөхөн бэлтгэх замаар компанийн тогтвортой үйл ажиллагааг ханган ажиллахад оршино.

Дөрөв: Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Иргэдийн төлөөлөгчийн хурлын 2025 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 8-р хуралдааны 59 тогтоолоор 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 634.3 сая төгрөг, нийт зардлыг 606.3 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Өмнөх оны үлдэгдэл 317.2 сая төгрөг бол гүйцэтгэлээр 439.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 515.1 сая төгрөгийн зарцуулалттай ажилласан байна.

Тав. Аудитын гол асуудал

Тус газар нь тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,434.5 сая төгрөгийн төсөв баталж улсын төсвөөс 1,119.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны өөрийн орлогоос 65.0 сая төгрөгөөр төлөвлөж дээд шатны байгууллагад хүргүүлж гүйцэтгэлээр Улсын төсвөөс 1,119.6 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал зардалд 1,110.8 сая төгрөгийг зарцуулж, үндсэн үйл ажиллагааны орлогоос 65.0 сая төгрөгийн зарцуулах эрх авч 160.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж оны эцэст улсын төсөвт 107.8 сая төгрөгийн хэмнэлт гарган татан төвлөрүүлж ажилласан байна.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүйгээс 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээсэн.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн оруулах, төсвийг зохистой удирдах

Найм. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 201.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 1.0 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 200.7 сая төгрөгийн 5 зөвлөмжийг өгсөн.

Нийт илрүүлсэн 201.7 сая төгрөгийн алдаа, зөрчил үүссэнээс материаллаг 1,000.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилтэй байгаа нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2080.4 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

8.1 Төлбөрийн акт

1. Аудитын илрүүлэлт:

"Хөдөө аж ахуй, хөгжлийн ирээдүй" ОНӨХХК нь 7 албан хаагчдадаа 3500.0 мянган төгрөгийн түлшний дэмжлэг үзүүлсэн боловч захирал нь өөртөө тушаал гаргаж 500.0 мянган төгрөгийн хөнгөлөлт авсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалттай нийцээгүй.

Анхан шатны баримтын бүрдэлгүй 500.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6,13.7 дахь заалттай нийцээгүй.

2. Аудитын илрүүлэлт:

Анхан шатны баримтын бүрдэлгүй 500.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6,13.7 дахь заалтыг мөрдөж ажиллаагүй.

түрээс төлөхөөр 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдөр түрээсийн гэрээ байгуулж ажилласан ч гэрээнд заасан банкны дансанд төлбөрийг шилжүүлээгүй													
	7	201,678.3	2	1,000.0			5	200,678.3					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Дүн						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Дүн						
Нийт дүн						